

Салбар, төлөөлөгчийн газарт шинээр зөвшөөрөл олгох

1. Төв байгууллага нь салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа явуулах хүсэлтээ Гадаадын иргэн, харьяатын газарт гаргана.

2. Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа явуулах хүсэлтийг дараах этгээдийн аль нэг нь гаргана:

- Салбар, төлөөлөгчийн газрын төв байгууллагын гүйцэтгэх удирдлага;
- Итгэмжлэлээр эрх олгогдсон этгээд.

3. Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа явуулах хүсэлт гаргахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт		
№	Баримт бичиг	Шаардлага
1	Үйл ажиллагаа явуулах тухай хүсэлт.	Албан бичгээр
2	Салбар, төлөөлөгчийн газрын тэргүүний мэдүүлэг.	Албан бичгээр
3	Салбар, төлөөлөгчийн газар нээн ажиллуулах тухай төв байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр.	Албан бичгээр
4	Төв байгууллагын дүрмийн хуулбар	Хуудас тус бүр дээр тухайн байгууллагын тамга, тэмдгийг дарж баталгаажуулсан байх
5	Төв байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн нэр, хаяг, утас, цахим хаяг, иргэний бүртгэлийн дугаар бүхий танилцуулга	Албан бичгээр
6	Төв байгууллагын гэрчилгээний хуулбар	Тухайн улсын нотариатчаар гэрчлүүлсэн байна/, эсхүл тухайн улсын эрх бүхий байгууллагын тодорхойлолт
7	Санхүүжилтийн эх үүсвэрийн талаарх баримт бичиг	Төв байгууллагын үйлчлүүлэгч банкны тодорхойлолт
8	Салбар, төлөөлөгчийн газрын дүрэм, үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлэх хугацаа, төсөв	Албан бичгээр
9	Салбар, төлөөлөгчийн газрын тэргүүнд төв байгууллагаас олгосон итгэмжлэл, түүний паспорт, эсхүл иргэний үнэмлэхийн хуулбар	Албан бичгээр
10	Гэмт хэрэгт ял шийтгэгдэж байсан эсэх талаарх харьяалах улсын цагдаагийн байгууллагын тодорхойлолт	Албан бичгээр
11	Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт	Албан бичгээр

4. Дээрх бүрдүүлэх баримт бичиг гадаад хэл дээр үйлдэгдсэн бол орчуулга, "Апостиль" гэрчилгээ, нотариатч, эсхүл нотариатчийн үүрэг хавсран гүйцэтгэгчээр гэрчлүүлсэн хувийг хавсаргана.

5. Салбар, төлөөлөгчийн газрын нэр кирилл үсгээр илэрхийлэгдсэн байх бөгөөд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын тогтоолоор батлагдсан "Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журам"-ын дагуу хуулийн этгээдийн нэрэнд тавигдах шаардлага, хязгаарлалтыг хангасан байна.

6. Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт заасан баримт бичгийг Газрын тухайн асуудлыг хариуцсан нэгж нь хянан үзэн, гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, холбогдох байгууллагын санал авсаны үндсэн дээр Зөвлөлийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлнэ. Зөвшөөрөл олгох эсэх асуудлыг 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

7. Салбар, төлөөлөгчийн газарт зөвшөөрлийг 1 /нэг/ жилийн хугацаагаар олгоно.

8. Салбар, төлөөлөгчийн газар өөрийн харилцагч банкны нэр, дансны дугаарыг Гадаадын иргэн, харьяатын газрын хариуцсан мэргэжилтэнд бүртгүүлнэ.

9.

№	Банк	Дансны дугаар	Улсын тэмдэгтийн хураамж
1	Голомт банк	1320000052	900.000 төгрөг

- Төлбөр төлсөн баримтыг хавсаргах